



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 09 сарын 22 өдөр

Дугаар А/357

Улаанбаатар хот

Ариутгал, халдваргүйжүүлэлтийн багийн
бүрэлдэхүүнийг томилох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.3, Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.1, Монгол Улсын Шадар Сайдын 2020 оны "Стратеги, төлөвлөгөө батлах тухай" 26 дугаар тушаалын 3.9.4, Иргэний нисэхийн үндэсний төвийн дүрмийн 4.2.7 дахь заалт, Эрүүл мэнд, Нийгмийн хамгааллын сайдын 2000 оны 171 дүгээр тушаалын 3 дахь заалт, MNS ISO 45005:2021 стандартын 4.4.1.2 (a), 10.3 (d) заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдвар /ковид-19/ голомтлон тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор Иргэний нисэхийн үндэсний төвийн харьяа салбар нэгжийн ажлын байр, нэвтрэх цэг, албаны тээврийн хэрэгсэлд өдөр тутмын ариутгал, халдваргүйжүүлэлт хийх багийг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:

- | | |
|-----------------------|--|
| Багийн дарга: | Б.Бат-Эрдэнэ (Аэродром, барилга байгууламжийн ашиглалтын албаны ерөнхий менежер) |
| Нарийн бичгийн дарга: | М.Мөнхцэцэг ("Буянт-Ухаа" Нисэх буудлын ашиглалтын хэсгийн терминал, үйлчилгээний тасгийн үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн) |
| Ариутгагч: | П.Зоригт (Аюулгүй байдал, хамгаалалтын албаны Хөдөлмөрийн аюулгүй байдлын мэргэжилтэн) |
| | Д.Алтановч (Аэродром, барилга байгууламжийн ашиглалтын албаны Барилга, байгууламж, засварын хэсгийн тохижилт, засвар үйлчилгээний ажилтан) |
| | Л.Баярмаа (Аэродром, барилга байгууламжийн ашиглалтын албаны Барилга, байгууламж, засварын хэсгийн тохижилт, засвар үйлчилгээний ажилтан) |
| | Б.Дүгэрсүрэн (Иргэний нисэхийн үндэсний төвийн гэрээт ажилтан) |
| | Ч.Наранчимэг (Иргэний нисэхийн үндэсний төвийн гэрээт ажилтан) |
| | Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын албаны шалгах механик (ээлжийн хуваариар) |

2. Ажлын байрны дотоод ариутгалыг өдөр бүр, мэргэжлийн байгууллагын ариутгал, халдваргүйжүүлэлтийг 14 хоног тутам хийлгэж, ариутгагч нарт халдвараас хамгаалах иж

бүрэн хувцсыг заагдсан нормоор болон ажилласан өдрөөр тооцон хор саармагжуулах бүтээгдэхүүн олгох, ариутгал, халдваргүйжүүлэлтийг зохих журам, заавар, зааварчилгаа, хуваарийн дагуу зохион байгуулах, мэргэжлийн байгууллагаас холбогдох сургалт, дадлага авах, шаардлагатай нөөцийг бүрдүүлэхийг багийн дарга (Б.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

4. Алслагдмал объектууд, нэвтрэх цэгүүдийн ариутгал, халдваргүйжүүлэлтийг хийх үед ариутгагч нарыг тээврийн хэрэгслээр хангаж ажиллахыг Газрын тусгай үйлчилгээ, шатахуун хангалтын албаны дарга (Б.Батбаатар)-д үүрэг болгосугай.

5. Ариутгал, халдваргүйжүүлэлт, тээвэрлэлт, халдвараас хамгаалах хувцас, хэрэгсэл болон хор саармагжуулах бүтээгдэхүүнтэй холбогдон гарах зардлыг төсөвлөн зарцуулахыг Санхүү, эдийн засаг төлөвлөлтийн газар (Б.Батхишиг)-т зөвшөөрсүгэй.

6. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Иргэний нисэхийн үндэсний төвийн Гамшгаас хамгаалах штаб (П.Гантөгс) болон Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудал хариуцсан ажилтнуудад, орон нутгийн гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэгтэй уялдуулан орон нутгийн нисэх буудлуудын ариутгал, халдваргүйжүүлэлтийг зохих заавар, зөвлөмжийн дагуу хийхийг нисэх буудлын дарга нарт даалгасугай.

ДАРГА  П.МӨНХЖАРГАЛ

